

**МОНГОЛЫН ТҮҮХИЙН ЦАХИМ ТАЙЛБАР ТОЛЬД ОРОХ
ТОЛГОЙ ҮГИЙГ БИЧИХ
ТОВЧ ЗААВАР**

I. ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- Бичвэр нь Times New Roman фонтоор, үсгийн хэмжээ 11, 20-25 мөр хэмжээтэй байна. Энд хүснэгтэд оруулах мэдээллийг тооцохгүй.
- Богино өгүүлбэрээр, энгийн ойлгомжтой хэл найруулгаар бичнэ.
- Ямар нэгэн анги бүлэг, хүний үзэл бодол, байр суурийг тусгасан үг хэллэг, субъектив байр сууринаас аль болох зайлсхийж, түүхэн бодит байдлыг байгаа чигээр нь өгүүлнэ.

II. БҮТЭЦ

Толгой үг нь: I. Үндсэн мэдээлэл, II. Нарийвчилсан мэдээлэл, III. Үндсэн бичвэр гэсэн үндсэн хэсгүүдээс бүрдэнэ.

I. Үндсэн мэдээлэл

! Үндсэн мэдээллийн хүснэгтийг аль болох гүйцээж бичих.

II. Нарийвчилсан мэдээлэл

! Тодорхой биш, таамагласан он цагийг дөрвөлжин хаалт []-нд бичнэ.

ЖИШЭЭ: [1440 он]

! Он цаг нь тодорхойгүй тохиолдолд зууныг нь бичнэ.

ЖИШЭЭ: XIII зуун

III. Үндсэн бичвэр

Үндсэн бичвэр нь дараахь хэсгүүдээс бүрдэх бөгөөд доор дурдсан шаардлагуудыг хангасан байвал зохино.

1. [Тодорхойлолт]

! “Хэн, хэзээ, хаана, юу, яаж, яагаад” гэсэн асуултын дагуу, 1 өгүүлбэрт багтааж бичнэ. Өгүүлбэрийг нэр үгээр төгсгөнө.

ЖИШЭЭ: Улаанбаатар – Монгол улсын нийслэл.

! 1 мөр орчим хэмжээтэй, нэр үгээр төгсгөнө.

! “Цаг үе + бүс нутаг + хүн (объект) + агуулга + шинж чанар” гэсэн дарааллаар бичнэ.

(Тухайн төрлөөс хамааран бага зэрэг өөр байж болно.)

ЖИШЭЭ: Хиагтын 3 улсын гэрээ: 1915 онд Хиагт хотод Монгол, Орос, Дундад Иргэн улсын хооронд байгуулагдсан гэрээ

※ Харин зохиол бүтээл, түүхэн дурсгал, дурсгалт газрын хувьд “байршил + цаг үе + шинж чанар” гэсэн дарааллаар бичиж болно.

2. [Удам угсаа], [Үйл ажиллагаа], [Эрдэм ном, үзэл санаа], [Зохиол бүтээл], [Гавьяа шагнал] гэх мэт дарааллаар бичнэ. Толгойн үгийн төрлөөс хамаарч энэхүү бүтцэд өөрчлөлт орж болно.

3. [Ашигласан ном зохиол, Дэлгэрүүлэн унших ном зохиол]

! Энэ нь **Ашигласан ном зохиол, Дэлгэрүүлэн унших ном зохиол** гэсэн 2 үндсэн хэсгээс бүрдэнэ.

! *Эх сурвалж; судалгааны ном зохиол; өгүүлэл; сонины өгүүлэл* гэсэн ерөнхий дарааллаар бичиж, эдгээрийг тус бүрд нь үсгийн дараалалд оруулна.

! Монгол, дорно дахин, өрнө дахины ном зохиол гэсэн дарааллаар бичнэ.

! Ашигласан ном зохиолыг зохиогчийн нэрийн дарааллын дагуу бичнэ.

! Зохиогч, зохиолын нэр, хэвлэгдсэн газар, хэвлэлийн газар, он гэсэн дарааллын дагуу бичнэ. ЖИШЭЭ: Владимирцов Б.Я., *Общественный строй монголов. Монгольский кочевой феодализм*, Л.: Издательство Академий Наук СССР, 1934.

! Өгүүлэл болон сэтгүүлийн нэрийн хооронд // тэмдэг авна. Пэрлээ Х., “Шар тууж”-ийн зохиогчийн тухай // *Түүхийн судлал, боть VIII*, УБ., 1970

! Магистр, докторын зохиолыг зохиогчийн нэр, зохиолын нэр, ... их сургуулийн ... ухааны докторын зэрэг горилох бүтээл, он гэсэн дарааллаар бичнэ.

ЖИШЭЭ: Батбаяр С. *Монголын эдийн засгийн түүхийн асуудалд, МУИС-ийн түүхийн ухааны докторын зэрэг горилох бүтээл*, УБ., 2012

! Гадаад хэлээрх ном бүтээлийг тухайн хэлээр нь бичнэ.

ҮНДСЭН БИЧВЭРИЙН НАЙРУУЛГА, ҮГ ХЭЛЛЭГ

‡ Догол мөрнөөс эхлэх

4-6 өгүүлбэр бичсэний дараа догол мөрнөөс эхэлнэ.

‡ Түүхэн зүтгэлтэнтэй холбоотой хэсэгт дараахь зүйлсийг анхаарна.

① Хүний нэрийг онцгой тохиолдол (хаан, хатдын цол гэх мэт)-оос бусад тохиолдол тухайн хүний уг нэрийг хэрэглэнэ.

② Хүний нэрийг албан тушаалын хамт бичихдээ дараахь зарчмыг баримтална.

ЖИШЭЭ: ерөнхий сайд Х.Чойбалсан

③ Хүний нэрийн ард төрсөн, нас барсан оныг бичихгүй..

‡ Газар нутгийн нэрийн хувьд дараахь зарчмыг баримтална.

① Аймаг, сумын нэрийг анх бичихдээ албан ёсны нэрээр нь бичнэ.

ЖИШЭЭ: Архангайн Тариатын нутаг (буруу) → Архангай аймгийн Тариат сумын нутаг (зөв)

② Хуучны газар усны нэрийн ард шаардлагатай тохиолдолд дугуй хаалтанд өнөөгийн нэрийг нь бичиж болно.

ЖИШЭЭ: Дайчин вангийн хошуу (өнөөгийн Булган аймаг)

‡ Ханз үсэг, гадаад үгийг тэмдэглэх

Шаардлагатай тохиолдолд ханз үсэг болон гадаад үгийг дугуй хаалтад хийж болно.

ЖИШЭЭ: Да юань (大元)

ЖИШЭЭ: Потсдам (Potsdam)

‡ Он цагийг тэмдэглэх

① Зууны нэрийг ром тоогоор бичнэ. **ЖИШЭЭ: XVII зуун**

② Он цагийг товчилж бичихгүй.

ЖИШЭЭ: 1945.5.9. → 1945 оны 5 сарын 9

③ Аргын тооллын хамт билгийн тоолол юм уу, хаадын он тоолол, оны цолыг оруулах тохиолдолд дугуй хаалтад бичнэ.

ЖИШЭЭ: 1688 (Энх амгалангийн 27-р он)

ТҮҮХЭН ЗҮТГЭЛТЭН

[Үндсэн мэдээлэл]

Толгой үг	
Адил утгатай үг	
Хамаа бүхий үг	
Төрөл	
Цаг үе	
Хэний хаанчлалын үед	
Салбар	

[Тухайн төрөл доторхи нарийвчилсан мэдээлэл] Түүхэн зүтгэлтэн

Өөр нэр (цол, сүмийн цол, хоч нэр гэх мэт)	
Хүйс	
Гөрсөн он, сар, өдөр	
Нас барсан он, сар, өдөр	
Овог, аймаг	
Гөрсөн газар	
Албан тушаал	
Гэр бүл (Эцэг, өвөг эцэг, эх, нагац өвөг, хадам эцэг, хүүргэн, эхнэр, нөхөр, хүү охин гэх мэт)	

[Үндсэн бичвэр] ※ Төрөл тус бүр тогтсон дарааллын дагуу бичнэ. Жишээ нь: “Түүхэн зүтгэлтэн” хэмээх төрөл нь ([Годорхойлолт], [Удам угсаа], [Үйл ажиллагаа], [Эрдэм ном, үзэл санаа], [Зохиол бүтээл], [Гавьяа шагнал] гэх мэт дарааллаар бичнэ.

ТҮҮХЭН ҮЙЛ ЯВДАЛ

[Үндсэн мэдээлэл]

Толгой үг	
Адил утгатай үг	
Хамаа бүхий үг	
Төрөл	
Цаг үе	
Хэний хаанчлалын үед	
Салбар	

[Тухайн төрөл доторхи нарийвчилсан мэдээлэл] Түүхэн үйл явдал

Бүс нутаг	
Болсон цаг хугацаа	
Хаана болсон	
Холбогдох түүхэн хүн, аймаг угсаатан	

[Үндсэн бчвэр] ※ Төрөл тус бүр тогтсон дарааллын дагуу бичнэ. Жишээ нь: “Түүхэн үйл явдал” хэмээх төрөл нь ([Тодорхойлолт], [Гол агуулга], [Түүхэн шалтгаан], [Үйл явц], [Үр дүн] гэх мэт дарааллаар бичнэ.

ОВОГ АЙМАГ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

[Үндсэн мэдээлэл]

Толгой үг	
Адил утгатай үг	
Хамаа бүхий үг	
Төрөл	
Цаг үе	
Хэний хаанчлалын үед	
Салбар	

[Тухайн төрөл доторхи нарийвчилсан мэдээлэл] Овог аймаг

Үндэслэн байгуулагч	
Угсаа	МОНГОЛ
Бүс нутаг	
Үүсч байгуулагдсан он цаг	
Татан буугдсан он цаг	
Салаа салбарууд	

[Үндсэн бичвэр] ※ Төрөл тус бүр тогтсон дарааллын дагуу бичнэ. Жишээ нь: “Овог аймаг” хэмээх төрөл нь ([Тодорхойлолт], [Үүсч байгуулагдсан үйл явц, зорилго], [Зохион байгуулалт, үүрэг], [Түүхэн өөрчлөлт] гэх мэт дарааллаар бичнэ.